



БУЛГАН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2013 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 71

Булган

Г Зөвлөл байгуулах тухай Г

Хөдөлмөр нийгмийн зөвшлийн 3 талт үндэсний хорооны 2012 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 05 дугаар тогтоолыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Хөдөлмөрийн бүтээмж, инновацийн Аймгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
2. Хөдөлмөрийн бүтээмж, инновацийн хөдөлгөөнийг өрнүүлж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг "Бүтээмж, инновацийн аймгийн зөвлөл"-ийн дарга /Аймгийн Засаг даргын орлогч/-д даалгасугай.

ДАРГА

Д.БАТСАЙХАН

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2013 оны 6 сарын 25-ны өдрийн 71 дүгээр
тогтоолын хавсралт

БҮТЭЭМЖ, ИННОВАЦИЙН АЙМГИЙН
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга	-Аймгийн Засаг даргын орлогч
Орлогч дарга	-Аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн дарга
Гишүүд	-Аймгийн Засаг Даргын Тамгын Газрын НХХ-ийн дарга -Аймгийн БСГ-ын дарга -Аймгийн ҮЭХ-ны дарга -Аймгийн АОЭХ-ны дарга -Аймгийн МСҮТ-ийн захирал -Аймгийн ХАА-н МСҮТ-ийн захирал
Нарийн бичгийн дарга	-Аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн хөдөлмөрийн харилцааны мэргэжилтэн

ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖИЙН ХӨДӨЛГӨӨНИЙГ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ӨРНҮҮЛЭХ АЖЛЫН УДИРДАМЖ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Хууль, эрхзүйн үндэслэл

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасан "...хөдөлмөрийн насны иргэдийг ажлын байраар хангах, тэдний цалин хөлс нь амьдрал ахуйд нь хүрэлцдэг болгох... зорилтын хүрээнд цалин, тэтгэврийн хэмжээг инфляцийн түвшин, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан нэмэгдүүлнэ." гэсэн нь энэхүү удирдамжийг боловсруулах эрхзүйн үндэслэл болж байна.

Дээрх үндэсний зорилтын хүрээнд аймгийн 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөрийн бүтээмжийн талаарх бодлого, үйл ажиллагаанд аймгийн салбар салбарын аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог тодорхой болгож орон нутгийн түвшинд "Бүтээмжийн хөдөлгөөн"-ийг өрнүүлж, хөдөлмөрийн бүтээмжийн талаарх нийгмийн ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр талууд хамтран ажиллахаар тусгагдсан болно.

Бүтээмжийн төлөвшил, хандлага

Бүтээмж нь үйлдвэрлэлийн явцад нэгж зардлаас гарсан үр ашиг буюу гарцын хэмжээ юм. Эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэхэд хүний болон материалын нөөцийг үр ашигтай ашиглах үүднээс бүтээмжийн үзүүлэлтээр үндэсний нөөц чадамжийг тодорхойлдог бөгөөд бүтээмжийн хөдөлмөрийн болон олон хүчин зүйлийн бүтээмж гэж ангилдаг байна.

Хөдөлмөрийн бүтээмж нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг түүнд зарцуулсан хөдөлмөрт харьцуулсан үзүүлэлт бөгөөд ажиллагчдын хөдөлмөрийн бүтээмжээс байгууллагын нийт бүтээмжийн хэмжээ хамаарч, ашиг, орлого, үйл ажиллагааны хүрээ, цалин хөлсний хэмжээ, ажлын байр нэмэгдүүлэх зэрэг олон хүчин зүйлд нөлөөлдөг.

Өнөөдөр дэлхийн эдийн засаг, зах зээлийн орчин улам бүр өрсөлдөөнтэй болж бизнесийн хувьд оршин тогтнох эсэх нь чанар, зардал, түгээлтийн хурд, оновчтой байдал зэрэг өрсөлдөөний давуу чанаруудыг хэрхэн оновчтойгоор хослуулж чадаж байгаагаас шалтгаалах болов. Альч улсын хувьд олон улсын ийм өрсөлдөөнт зах зээлд нэвтрэх цорын ганц арга зам бол өрсөлдөх чадварын гол үзүүлэлт болох бүтээмжийн дээшлүүлэх явдал гэж үзэж байна.

Өнөөдөр дэлхий нийтээр бүтээмж дээшлүүлэхийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, компанийн гүйцэтгэлийн ашиг алдагдлыг тооцох, удирдлагын мониторинг хийх зэрэгт хэрэглэж байсан бол компанийн нийгмийн хариуцлагын талаас буюу түүний үйл ажиллагааг үндэсний эдийн засагтай холбох өргөн хүрээнд хэрэглэх болоод байна.

Хөдөлмөрийн бүтээмжийн одоогоор байгууллагын түвшинд тооцдоггүй, хөдөлмөрийн зардлыг хугацаа болон цалин хөлсний зардлаар бус ажиллагчдын тоон үзүүлэлтээр тооцож байгаа нь цалин хөлс, хөдөлмөрийн бүтээмжийн уялдааг хангах, бүтээмжийг нэмэгдүүлэх нөөц боломжтой салбар, аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийг гаргахад хангалтгүй байна. Иймд хөдөлмөрийн бүтээмжийн тооцоо, судалгааг илүү тодорхой гаргаж, боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Түүнчлэн улсын хэмжээнд явагдсан цалин хөлс, бүтээмжийн судалгааны урьдчилсан дүнгээс үзвэл ААНБ-уудын түвшинд цалин хөлсийг нэмэгдүүлэхдээ бүтээмжийн өсөлтийг харгалзаж үздэггүй төдийгүй бүтээмжийн ач холбогдлыг ажил олгогч, ажиллагчид нь сайн мэддэггүй дүн гарчээ.

Азийн бүтээмжийн багууллагаас үйл ажиллагаагаа явуулах уриагаа “Маргаашаа өнөөдрөөс илүү сайн болгохын тулд” буюу “Making tomorrow better than today” хэмээн маш энгийн, ойлгомжтой байдлаар тодорхойлжээ. Ийм учраас бид ч мөн адил маргаашаа өнөөдрөөсөө илүү сайн сайхан болгохын тулд, эрхэлж буй ажлынхаа нөөц бололцоог илүү үр дүнтэй ашиглаж ахиу үр ашиг бий болгон, тогтвортой үйл ажиллагааны үндэс суурийг тавих хэрэгтэй байна. Тогтвортой үйл ажиллагаа нь эцсийн дүндээ баталгаатай ажлын байр, байнгын орлогыг бий болгодог.

Бүтээмжийн талаар дээр дурьдсан үндэслэл, шаардлага, төлөв хандлагыг үндэслэн Аймгийн Хөдөлмөрийн бүтээмж, инновацийн зөвлөл аймгийн хэмжээнд идэвхитэй үйл ажиллагаагаа явуулдаг ТББ-ууд хамтран аймгийн хэмжээнд хөдөлмөрийн бүтээмжийн хөдөлгөөн өрнүүлэх удирдамжийг боловсруулав.

ХОЁР. ХӨДӨЛГӨӨНИЙ ЗОРИЛГО

Орон нутаг, аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд хөдөлмөрийн бүтээмжийн хөдөлгөөн өрнүүлж, хөдөлмөрийн бүтээмжийн талаарх нийгмийн ойлголтыг дээшлүүлж, бүтээмжтэй ажиллах, үндэсний чадавхийг хөгжүүлэх, улмаар эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангаж, хүн амын амьдралыг сайжруулахад чиглэгдэнэ.

ГУРАВ. ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖИЙН ХӨДӨЛГӨӨН ӨРНҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД

3.1 Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн бүтээмжийн талаарх нийгмийн ойлголтыг нэмэгдүүлэх, төлөвшүүлэх

3.2 Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн бүтээмжийн хөдөлгөөний зорилтыг сурталчлах

3.3 Хөдөлмөрийн бүтээмжийн талаар сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах, бүтээмжийн чадавхи бүхий хүний нөөцийг бэлтгэх

3.4 Хөдөлмөрийн бүтээмжийг тооцох аргачлал, судалгаа хийх

3.5 Бүтээмжийн хөдөлгөөнийг идэвхитэй өрнүүлж буй байгууллага, аймаг, орон нутаг, Монголын Бүтээмжийн төв болон гадны орны бүтээмжийн байгууллагатай хамтран ажиллах, туршлага судлах, дэлгэрүүлэх, нийтийн хүртээл болгох

3.6 Хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх зохистой механизм, цалингийн боловсронгуй систем нэвтрүүлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, зөвлөмж боловсруулах

3.7 Хөдөлмөрийн бүтээмжтэй холбоотой гарын авлага боловсруулж, нийтийн хүртээл болгох

3.8 Хөдөлмөрийн бүтээмжийн үр дүнг үнэлэх, шагнал урамшууллын тогтолцоог бий болгох, журам боловсруулах

ДӨРӨВ. ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖИЙН ХӨДӨЛГӨӨН ӨРНҮҮЛЭХ ХҮРЭЭ

4.1 Аймгийн хэмжээнд

4.2 Салбар нэгжүүдийн түвшинд

4.3 Байгууллага, аж ахуйн түвшинд

ТАВ. ТАЛУУДЫН ҮҮРЭГ ОРОЛЦОО

Хөдөлмөрийн бүтээмжийн хөдөлгөөн өрнүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд аймгийн бүтээмж, инновацийн зөвлөл болон бүтээмжийн асуудал хариуцсан ТББ-ууд нь дараах чиглэлээр хамтран ажиллана.

5.1 Аймгийн хэмжээнд:

5.1.1 Аймгийн засаг дарга, ажил олгогч, үйлдвэрчний эвлэлийн холбоо нь аймгийн хэмжээнд хөдөлмөрийн бүтээмжийн чиглэлээр хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан баталж, үр дүнг тооцож ажиллана.

5.1.2 Аймгийн хэмжээнд орон нутгийн аж ахуйн нэгж байгууллагын хөдөлмөрийн бүтээмжийн судалгааг хийж, үр дүнг нэгтгэн, бүтээмжийн мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгоно.

5.1.3 Аймгийн засаг даргын тамгын газар, үйлдвэрчин, ажил олгогч эздийн холбоо, бүтээмжийн асуудал хариуцсан ТББ-ууд хамтран тухайн орон нутгийн аж ахуйн нэгж байгууллагад хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх арга хэрэгслийн талаар сургалт зохион байгуулж, загвар аж ахуйн нэгж байгууллагууд байгуулж, тэргүүн туршлагыг сурталчилна.

5.2 Салбар, нэгжийн түвшинд:

5.2.1 Салбарын түвшинд хөтөлбөр төлөвлөгөө боловсруулж, талуудын оролцоотой хэрэгжүүлнэ.

5.2.2 Салбар, нэгжийн онцлогт тохирсон хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх арга хэрэгсэл, бүтээмжийг тооцох аргачлалыг боловсруулж, ААНБ-уудад нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.

5.2.3 Салбарын түвшинд бүтээмж, инноваци хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулж, сургалтын хөтөлбөр, аргазүйн материал, гарын авлага боловсруулж, сургалт зохион байгуулна.

5.2.4 Тухайн салбарт хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтийг хангасан загвар аж ахуйн нэгж, байгууллагуудыг бий болгож, тэргүүн туршлагыг сурталчилж дэлгэрүүлнэ.

5.2.5 Бүтээмжийн шагнал урамшууллын тогтолцоог бий болгоно.

5.3 Аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд:

5.3.1 Ажил олгогч болон ажилтны эрх ашгийг төлөөлсөн үйлдвэрчний эвлэлийн хороо нь хамтран хөдөлмөрийн бүтээмжийн асуудлаар төлөвлөгөө боловсруулан хамтран хэрэгжүүлнэ.

5.3.2 Хамтын гэрээнд цалин хөлс, бүтээмжийн асуудлыг тусгаж, дүгнэнэ.

5.3.3 Хөдөлмөрийн бүтээмжийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх сургалтуудад ажилтнуудаа хамруулах, аргазүйн материал, гарын авлагаар хангана.

5.3.4 Цех, тасаг, албадын ажилтнуудын бүтээмжийг дүгнэж урамшуулна.

ЗУРГАА. ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮР ДҮН

6.1 Аймгийн хэмжээнд:

6.1.1 Орон нутагт үйл ажиллагаагаа явуулж буй байгууллага, аж ахуйн нэгжид хөдөлмөрийн бүтээмжийн судалгааг хийж, үр дүнг нэгтгэн, бүтээмжийн мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгосон байна.

6.1.2 Хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, түүнийг нэвтрүүлэх арга хэрэгслийн талаар сургалт зохион байгуулж хэвшсэн байна.

6.2 Салбарын түвшинд:

6.2.1 Салбарын түвшинд бүтээмжийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, хөтөлбөрийн дагуу цаашид хийх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, төлөвлөгөөний дагуу ажиллаж хэвшсэн байна.

6.2.2 Салбарын онцлогт тохирсон хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх арга хэрэгсэл, бүтээмжийг тооцох аргачлалыг боловсруулж, ААНБ-уудад нэвтрүүлсэн байна.

6.2.3 Салбарын түвшинд хөдөлмөрийн бүтээмжийн удирдлагын тогтолцоо бүрдсэн байна.

6.2.4 Салбарын онцлогт тохирсон бүтээмжийн аргазүйн материал, гарын авлагатай болсон байна.

6.2.5 Тухайн салбарт хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтийг хангасан загвар аж ахуйн нэгж байгууллагууд бий болсон байна.

6.2.6 Бүтээмжийн шагнал урамшууллын тогтолцоо бий болсон байна.

6.3 Аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд:

6.3.1 Хамтын гэрээнд цалин хөлс, бүтээмжийн асуудлыг тусгасан байна.

6.3.2 ААНБ үйл ажиллагааны цар хүрээнээс хамаарч орон тооны ажилтан ажиллуулсан, эсхүл бүтээмжийн асуудлыг хавсран гүйцэтгүүлж, ажлын байрны тодорхойлолтод тусгаж, тодорхой ажлуудыг хэрэгжүүлсэн байна.

6.3.3 Хөдөлмөрийн бүтээмжийн асуудлаар төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, үр дүнг тооцдог болсон байна.

6.3.4 Цалин хөлсийг бүтээмжийн өсөлтийг харгалзан нэмэгдүүлдэг болсон байна.

6.3.5 ААНБ-ууд хөдөлмөрийн бүтээмж дээшлүүлэх арга хэрэгслүүдийг хэрэгжүүлсэн байна.

6.3.6 ААНБ-ууд холбогдох сургалтуудад ажилтнуудаа хамруулж, тэдний мэдлэг чадавхийг нэмэгдүүлэн, аргазүйн материал, гарын авлагаар хангасан байна.

6.3.7 Цех, тасаг, албадын ажилтнуудын бүтээмжийг дүгнэж урамшуулах механизм бүрдсэн байна.

ДОЛОО. ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН ЗОХИЦУУЛАЛТ, ХЯНАЛТ

Хөдөлмөрийн бүтээмжийн хөдөлгөөнийг Аймгийн хөдөлмөрийн бүтээмж, инновацийн зөвлөл удирдах ба бүтээмжийн чиглэлээр ажиллах бүрэлдэхүүний ажиллах журам, үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг аймгийн бүтээмж, инновацийн зөвлөлийн дарга батална.

Ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд улирал тутам хяналт, үнэлгээ хийнэ.

Салбар нэгжүүд хийсэн ажлаа сар тутам тайлагнаж байх.

Бүтээмжийн хөдөлгөөний хэрэгжилтийн явцын тайланг аймгийн зөвлөл нэгтгэн хагас жил тутамд хөдөлмөрийн яам болон орон нутгийн удирдлагад тайлагнана.

АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ӨРНҮҮЛЭХ “БҮТЭЭМЖ-АЖЛЫН АМЖИЛТ” ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН НЭР: БҮТЭЭМЖ-АЖЛЫН АМЖИЛТ

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ХУГАЦАА: 2013-2016 он

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН УРИА: “Маргаашаа өнөөдрөөс илүү сайн, сайхан болгоё”

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Орон нутаг, салбар нэгж, байгууллага, аж ахуйн түвшинд хөдөлмөрийн бүтээмжийн хөдөлгөөн өрнүүлж, хөдөлмөрийн бүтээмжийн талаарх нийгмийн ойлголтыг дээшлүүлж, бүтээмжтэй ажиллах, үндэсний чадавхийг хөгжүүлэх, улмаар эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангаж, хүн амын амьдралыг сайжруулахад чиглэгдэнэ.

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

5.1 Аймгийн төр, төсвийн байгууллага

5.2 Аймгийн төрийн бус байгууллага

5.3 Ажил олгогч эздийн холбоо

5.4 Үйлдвэрчний эвлэлийн хороо

5.5 Хувийн аж ахуйн нэгж, үйлдвэр, хоршоо, иргэд

ЗУРГАА. ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖИЙН ХӨДӨЛГӨӨН ӨРНҮҮЛЭХ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД

6.1 Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн бүтээмжийн талаарх нийгмийн ойлголтыг нэмэгдүүлэх, төлөвшүүлэх

6.2 Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн бүтээмжийн хөдөлгөөний зорилтыг сурталчлах

6.3 Хөдөлмөрийн бүтээмжийн талаар сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах, бүтээмжийн чадавхи бүхий хүний нөөцийг бэлтгэх

6.4 Хөдөлмөрийн бүтээмжийг тооцох аргачлал, судалгаа хийх

6.5 Бүтээмжийн хөдөлгөөнийг идэвхитэй өрнүүлж буй байгууллага, аймаг, орон нутаг, Монголын Бүтээмжийн төв болон гадны орны бүтээмжийн байгууллагатай хамтран ажиллах, туршлага судлах, дэлгэрүүлэх, нийтийн хүртээл болгох

6.6 Хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх зохистой механизм, цалингийн боловсронгуй систем нэвтрүүлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, зөвлөмж боловсруулах

6.7 Хөдөлмөрийн бүтээмжтэй холбоотой гарын авлага боловсруулж, нийтийн хүртээл болгох

6.8 Хөдөлмөрийн бүтээмжийн чиглэлээр салбар бүрт төлөвлөгөө боловсруулан ажиллаж, хэрэгжилтийг хангаж, гүйцэтгэлийг тайлагнах

6.9 Хөдөлмөрийн бүтээмжийн үр дүнг үнэлэх, шагнал урамшууллын тогтолцоог бий болгох, журам боловсруулах

ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

7.1 Аймгийн хөдөлмөрийн бүтээмж, инновацийн зөвлөл нь хөтөлбөрийн хэрэгжилтийг мэргэжил, аргагүйн удирдлага, зохицуулалтаар хангах бөгөөд хөтөлбөрийн хүрээнд зарцуулах хөрөнгийг аймгийн төсөвт оруулж батлуулсан хөрөнгөөр хуваарилалт хийнэ.

7.2 Хөдөлмөрийн бүтээмж, инновацийн зөвлөл болон салбар, нэгжүүдийн тэргүүлэгчид нь хөтөлбөрийн хүрээнд хөдөлмөрийн бүтээмжийн сургагч багш нарыг чадавхижуулах, мэргэшүүлэх сургалтанд оролцох ажлыг зохион байгуулах, ном, гарын авлага, материал боловсруулах, сургалт зохион байгуулах, төлөвлөгөө гаргах, хэрэгжилтийг хангах зэрэг ажлуудыг зохион байгуулж оролцоно.

НАЙМ.ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

8.1 Орон нутгийн төсвөөс

8.2 Байгууллага, аж ахуйн нэгжийн төсвөөс

ЕС. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН

9.1 Аймгийн хэмжээнд:

9.1.1 Орон нутагт үйл ажиллагаагаа явуулж буй байгууллага, аж ахуйн нэгжид хөдөлмөрийн бүтээмжийн судалгааг хийж, үр дүнг нэгтгэн, бүтээмжийн мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгосон байна.

9.1.2 Хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, түүнийг нэвтрүүлэх арга хэрэгслийн талаар сургалт зохион байгуулж хэвшсэн байна.

9.2 Салбарын түвшинд:

9.2.1 Салбарын түвшинд бүтээмжийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, хөтөлбөрийн дагуу цаашид хийх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, төлөвлөгөөний дагуу ажиллаж хэвшсэн байна.

9.2.2 Салбарын онцлогт тохирсон хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх арга хэрэгсэл, бүтээмжийг тооцох аргачлалыг боловсруулж, ААНБ-уудад нэвтрүүлсэн байна.

9.2.3 Салбарын түвшинд хөдөлмөрийн бүтээмжийн удирдлагын тогтолцоо бүрдсэн байна.

9.2.4 Салбарын онцлогт тохирсон бүтээмжийн аргазүйн материал, гарын авлагатай болсон байна.

9.2.5 Тухайн салбарт хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтийг хангасан загвар аж ахуйн нэгж байгууллагууд бий болсон байна.

9.2.6 Бүтээмжийн шагнал урамшууллын тогтолцоо бий болсон байна.

9.3 Аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд:

9.3.1 Хамтын гэрээнд цалин хөлс, бүтээмжийн асуудлыг тусгасан байна.

9.3.2 ААНБ үйл ажиллагааны цар хүрээнээс хамаарч орон тооны ажилтан ажиллуулсан, эсхүл бүтээмжийн асуудлыг хавсран гүйцэтгүүлж, ажлын байрны тодорхойлолтод тусгаж, тодорхой ажлуудыг хэрэгжүүлсэн байна.

9.3.3 Хөдөлмөрийн бүтээмжийн асуудлаар төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, үр дүнг тооцдог болсон байна.

9.3.4 Цалин хөлсийг бүтээмжийн өсөлтийг харгалзан нэмэгдүүлдэг болсон байна.

9.3.5 ААНБ-ууд хөдөлмөрийн бүтээмж дээшлүүлэх арга хэрэгслүүдийг хэрэгжүүлсэн байна.

9.3.6 ААНБ-ууд холбогдох сургалтуудад ажилтнуудаа хамруулж, тэдний мэдлэг чадавхийг нэмэгдүүлэн, аргазүйн материал, гарын авлагаар хангасан байна.

9.3.7 Цех, тасаг, албадын ажилтнуудын бүтээмжийг дүгнэж урамшуулах механизм бүрдсэн байна.

АРАВ. ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН ЗОХИЦУУЛАЛТ, ХЯНАЛТ, МЭДЭЭЛЭЛ

Хөдөлмөрийн бүтээмжийн хөдөлгөөнийг Аймгийн Хөдөлмөрийн бүтээмж, инновацийн зөвлөл удирдах ба бүрэлдэхүүний ажиллах журам, үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг Аймгийн бүтээмж, инновацийн дарга батална.

Ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд улирал тутам хяналт, үнэлгээ хийнэ.

Салбар нэгжүүд хийсэн ажлаа сар тутам тайлагнаж байх.

Бүтээмжийн хөдөлгөөний хэрэгжилтийн явцын тайланг аймгийн зөвлөл нэгтгэн хагас жил тутамд хөдөлмөрийн яам болон орон нутгийн удирдлагад тайлагнана.